

“КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД”

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН
ЭХНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ





Konrad
Adenauer
Stiftung

Хаяг: Konrad-Adenauer-Stiftung
Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар,
Сөүлийн гудамж, Браухаус-22,
Улаанбаатар 210628

Утас: +976 11 31 91 35 oder -136

Факс: +9 76 11 31 91 37
Info.mongolia@kas.de



CORPORATE
GOVERNANCE
DEVELOPMENT
CENTER

Хаяг: СЭЗИС-ийн хичээлийн С корпус,
С-1105 тоот өрөө, Энхтайвны өргөн чөлөө 5,
113381 Улаанбаатар

Утас: 7000 8084, 99105111, 88978179

Факс: 7000 8084

Email: Info@cgdc.org.mn

“КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД” ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ЭХНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Огноо: 2017.09.19

Эхэлсэн цаг: 09.00

Дууссан цаг: 12.00

Хаана: Нээлттэй нийгэм форум



ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
ЗОРИЛГО:

Монгол Улсын тогтвортой хөгжилд бизнесийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг нэгтгэн тодорхойлох, ингэхдээ зөвхөн компаниудаас гадна бизнесийн холбоод, бусад ТББ, судлаачдын хүрээнд илүү өргөн утгаар асуудлыг харж томъёолох зорилго тавьж хэлэлцүүлгийг өрнүүлэв.



ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
ҮР ДҮН:

Оролцогч бүх талуудын дунд танилцуулсан Конрад-Аденауэр-Сан /КАС/ Компанийн Засаглалын Хөгжлийн Төв /CGDC/-ийн хамтран хийсэн судалгааны үр дүн болон хамтран санал болгож буй ирэх онд хийгдэх ажлуудыг тусгасан газрын зургийг хэлэлцүүлэн санал, туршлага солилцож нэгдмэл үр дүнд хүрэв.

ХӨТӨЛБӨР:



Хэлэлцүүлгийг нээж Монгол дахь Конрад-Аденауэр- Сангийн суурин төлөөлөгч, доктор **Даниел Шмюкинг** үг хэллээ.



Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал **Т.Цэнд-Аюуш** хэлэлцэх асуудал, хүлээгдэж буй үр дүнгийн талаар товч танилцуулга хийлээ.



“Тогтвортой хөгжлийн зорилтууд-Дэлхийн хөгжлийн хөтөлбөр 2030” сэдвээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагчийн газрын мэргэжилтэн **А.Цэцэгмаа** илтгэл тавилаа.



CGDC-ийн зөвлөх, доктор **Мануэла Гласс** “Компанийн Нийгмийн Хариуцлага болон ТХЗ-ын Судалгааны үр дүнгийн танилцуулга”-ыг хийлээ.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД:



Амаржаргал Сан
Р.Амаржаргал



Монос Групп
С.Баянмөнх



Монголын
Бизнесийн Зөвлөл
П.Чимэдням



Зориг Сан
Б.Цолмон



СЭЗИС
Д.Батжаргал



Ерөнхий сайдын
ахлах зөвлөх
Н.Энхбаяр



Эдийн Засгийн
Бодлого, Өрсөлдөх
Чадвар Судалгааны Төв
Б.Лэгшми



Эрдэнэс Монгол ХХК
Б.Мэндбаяр



Нова Терра ХХК
Б.Итгэл

Бүртгэл

Нээлтийн үг Др.Даниел Шмюкинг(КАС), Т.Цэнд-Аюуш (CGDC)

Танилцуулга I

ТХЗ-уудын Монгол Улсын ирээдүйд үзүүлэх ач холбогдлын тухай, ТХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлэхэд хувийн секторуудын үүрэг (А. Цэцэгмаа UN)

Танилцуулга II

КНХ болон ТХЗ-ын Судалгааны үр дүнг танилцуулах (Мануэла Гласс)

Оролцогч талуудын дуу хоолой

Монголд ТХЗ-ийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлууд болон хамтын ажиллагаагаа сайжруулах, яриа хэлэлцүүлгийг амжилтанд хүргэх арга замын талаар төлөөллүүд ярилцах (CGDC-ээс боловсруулсан 3-н асуулт дээр үндэслэн оролцогч талуудын төлөөллүүд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болон бусад хийж болох зүйлсийн талаар санаануудаа хэлэлцэх)

- Компани (7 минут)
- Бизнесийн холбоо (7 минут)
- Боловсролын байгууллага (7 минут)
- ТББ (7 минут)

Асуулт хариулт (2 минут)

Хэлэлцүүлэг I

Хүлээлт болон одоогийн гүйцэтгэлийн талаар оролцогч талуудын ойлголт дээр санал солилцох (20 минут)

Хэлэлцүүлэг II (Зохицуулагчид + оролцогчид)

- Монгол дахь оролцогч талуудын хамтын ажиллагаа, яриа хэлэлцээг сайжруулах алхамуудыг тодорхойлох (30 минут)
- 2018/2019 оны хийгдэх алхамуудын зураглал (roadmap)-ыг тодорхойлох (15 минут)

Дүгнэлт Др.Даниел Шмюкинг (КАС)



Konrad
Adenauer
Stiftung



CORPORATE
GOVERNANCE
DEVELOPMENT
CENTER

Танилцуулга II

Монголын КНХ/ТХЗ-уудын судалгаа, шилдэг практикууд болон
хамаарагч талуудын амжилттай хамтын ажиллагааны боломжууд

CGDC-ийн зөвлөх, доктор Мануэла Гласс

Хэсэг I

Монгол дахь судалгаа

Үндсэн ойлголт

Зорилго:

- ✓ КНХ ба ТХЗ-ууд, тэдний хэрэгжилт, боломж бололцоо ба саад бэрхшээлүүдийн талаарх Монголын бизнесийн хүрээнийхний санал бодлыг тодорхойлон нэгтгэх
- ✓ Улсын тогтвортой хөгжилд Монгол компаниудын гүйцэтгэж буй үүргүүдийг тодорхойлох
- ✓ Оролцогч талуудын хоорондын төлөвлөж буй хамтын ажиллагаанд зориулсан зөвлөмжүүдийг гаргах

Хандалт:

- ✓ 2017 оны 3-5 сард 49 компани, 5 бизнесийн холбоо ба 5 ТББ-тэй ярилцлага хийж олон улс дахь үр дүнгүүдтэй харьцуулсан

► 3

Монгол дахь судалгааны ерөнхий үр дүн



КНХ ба ТХЗ-уудтай уялдаж ажилласнаар бий болох нэмэлт үнэ цэнийг бизнесийн орчныхон хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд илүү хүчтэй, идэвхтэй оролцохыг эрмэлзэж байна.



КНХ/ТХЗ-уудын арга хэмжээнүүдийн хэрэгжилт доогуур түвшинд байгаа.

Илрүүлсэн шалтгаанууд:


- Монголын бизнесийн соёл, хууль эрх зүй, улс төрийн тогтолцоо
- Мэдлэг мэдээлэл дутсанаар хүлээж авах, ойлгох, дэмжих нь сул
- Компанийн хувь нэмэр, оролцоог улс төр ба олон нийтээс хүлээн авч ойлгож дэмжих нь дутмаг

Үр дүнгээс гарч буй шаардлага:

- ✓ Хариуцлагатай бизнесийг (КНХ/ТХЗ-ууд) санхүүгийн ба санхүүгийн бус хэлбэрээр дэмжих


► 4

Задаргаа I: Монголын компаниуд ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд өөрсдийн үүргийг хэрхэн тодорхойлж байгаа нь




▶ 5

Задаргаа II: Компанийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ



▶ 6

Задаргаа III: Компаниудыг идэвхтэй оролцуулахад гарч буй саад бэрхшээлүүд



▶ 7

Монголын судалгаа: Илүү сайн хамтын ажиллагаа ба хариуцлагатай бизнесийг дэмжих ТОП 5 арга хэмжээнүүд



▶ 8

Семинарын зорилтод төвлөрсөн гол үр дүнгүүд

- Харилцан ярилцах, Хамтын ажиллагаа, Таниулан мэдүүлэх болон Хүлээн зөвшөөрч дэмжих чиглэлээр ажлаа сайжруулах
- Бизнес, улс төр ба засаг захиргааны дунд хамтарсан хариуцлагыг тогтоох

Суурь ойлголт:

- Компанийн зүгээс илүү хариуцлагатай бизнест хөрөнгө оруулах нь улс төр ба олон нийтийн зүгээс ойлгож дэмжихээс хүчтэй хамаардаг.

Нөхцөлүүд:

- ✓ Компаниуд яриа хэлэлцээ, холбоо харилцаагаар дамжуулан санал бодол, асуудал бэрхшээл ба хамтарсан шийдлүүдийг ил тодоор солилцох замаар итгэлцлийг бий болгох (дотроо болон компанийн хил хязгаараас гадуур) шаардлагатай
- ✓ Дэмжих сэтгэл зүйг бий болгох, бусдыг араасаа дагуулахын тулд компаниуд, тэр дотроо тэдний манлайлагчид загвар болохуйц байх ёстой

Хэсэг II

Олон улсын туршлага: ТХЗ-ууд ба хамаарагч талуудын амжилттай хамтын ажиллагаануудаас бий болсон нэмэлт үнэ цэнэ

ОУ-ын туршлага I: ТХЗ-уудын нэмэлт үнэ цэнэ

Нийгмийн хэрэгцээнд тохируулах

- Жишээ: Эрүүл мэнд, хүнс, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлээр хөрөнгө оруулалт ба шинэ санаачлага

Боломжит үр нөлөө

- Орлогын шинэ эх үүсвэр ба шинэ зах зээл
- Тогтвортой хөгжлийн стратегиудыг үндэсний ба ОУ-ын зорилтуудтай уялдуулах

Нэр хүндийн өгөөж

- Капиталын ба гадаад ХО-уудын боломж өсөх
- Чадвартай ба сэдэлжсэн ажилтнууд
- Үр өгөөжийн өсөлт ба зардлын бууралтаар компанийн үнэ цэнэ өсөх

▶ 11


ОУ-ын туршлага II: Хариуцлагатай бизнесүүд нь “байх ёстой норм” болж байна

- ▶ Хэрэглэгчдийн нөлөө улам өсөж байна
- ▶ Хэрэглэгчид компаниудаас ашгаа хийхийн зэрэгцээ нийгэм ба байгаль орчны хувьд хариуцлагатай байхыг хүсэж байна
- ▶ Хариуцлагын тухай ярьж өөрсдийн оролцоог харуулж баталж чаддаг компаниуд л хариуцлагатай байж чадна гэдэгт ихэнх хэрэглэгчид итгэдэг

▶ 12

Дэлхий нийтийн итгэлцлийн хямралын хүрээн дэх оролцогч талуудын олон түвшинт яриа хэлэлцээ I

Дэлхийн хандлага	Оролцогч талуудын харилцаа холбоо (агуулгууд, хүлээлтүүд, хэрэгжих боломж) чухал болж байна
Бэрхшээл	ТХЗ-үүд нь хувь компаниудын хувьд хангалттай хэмжээнд тодорхой, нарийн задарсан болж чадаагүй байна
Үр дүн	Сайн харилцаа холбоо ба манлайлал эрэлт өндөртэй байна



▶ 13

Дэлхий нийтийн итгэлцлийн хямралын хүрээн дэх оролцогч талуудын олон түвшинт яриа хэлэлцээ II

- ▶ **(1) Групп дотроо ярилцах**, Жишээ: Хувь компаниуд: ТХЗ-уудыг ойлгох, компанийн уялдаатай зорилтууд ба тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, шинэ хөрөнгө оруулалтуудыг авч үзэх, шинэ санаа санаачлагууд
- ▶ **(2) Оролцогч талуудын ярилцлага** болон дотоод, гадаад харилцаа холбоо “Үйл ажиллагаа явуулах лиценз”
- ▶ **(3) Мэдлэг солилцоо** болон хэрэгжилтэнд гарч буй ахиц дэвшил, саад бэрхшээлүүдийн тухай байнгын, нээлттэй мэдээлэл солилцоо (үлс төр, засаг захиргаа, бизнес, нийгэм олон нийт)

! Гүйцэтгэл, ойлголцолд урам хугарснаар дахин үл итгэлцэл үүсэхээс сэргийлэхийн тулд оролцогч тал бүр өөрсдийн үүрэг, хариуцлага болон боломж хязгаараа тодорхойлж томъёолох ёстой

! Үүний зэрэгцээ компаниуд үлс төрийнхөн, ТББ-үүд болон бусад хамаатай талуудын гүйцэтгэх үүрэг, түүний үндэслэл нөхцөлүүдийг ойлгохыг оролдох ёстой.

▶ 14

Нэгтгэл

Монголын
компаниуд/олон улсын
компаниудын өнцгөөс
авч үзэхэд гарах үндсэн
саад бэрхшээлүүд

Хандалт

- ✓ Яриа хэлэлцээ ба хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих
- ✓ Таниулан мэдүүлэх ба хүлээн зөвшөөрөхийг хөхүүлэн дэмжих

Хамаарагч талуудын 3 түвшинт яриа хэлэлцээ нь анхны алхам болно



Семинарын зорилтууд:

- Монголын нөхцөлд оролцогч талуудтай хийх яриа хэлцлийн агуулга, нөхцөлүүд болон зорилгыг тодорхойлох
- 2018 онд хийгдэх алхамуудаа тодорхойлох (roadmap)

▶ 15





Компанийн Нийгмийн Хариуцлага-Тогтвортой Хөгжлийн ойлголтууд, энэ чиглэлд хийж байгаа ажлуудынхаа туршлагыг Амаржаргал Сан, Монос Групп, Зориг Сан, СЭЗИС, Монголын Бизнесийн Зөвлөлийн төлөөллүүд танилцууллаа.





✉ sdg.dialogue@ufe.edu.mn

☎ 976-7000 8084

📍 Монгол Улс, Улаанбаатар хот,
Энхтайвны өргөн чөлөө-5,
СЭЗИС, С байрны 1105

Тогтвортой хөгжлийн зорилтуудын чиглэлд 2018-2019 онд хийх алхмуудын зураглалыг Компанийн Засаглалын Хөгжлийн Төв /CGDC/- өөс санал болгож, оролцогчдын саналыг хүлээн авах

sdg.dialogue@ufe.edu.mn

и-мэйл хаягийг үүсгэв.



Шийдэх асуудлууд

Нийтлэг хандлагууд ба дараагийн алхамууд

Судалгаанд оролцогчдоос тодорхойлсон гол шийдэх асуудлуудыг эргэж авч үзэх нь

- ✓ Бизнесийн хүрээнийхний хоорондын болон улс төр, засаг захиргаа, иргэний нийгэм, олон нийттэй хийх яриа хэлэлцээ ба хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих
- ✓ Улс төр, засаг захиргаа, иргэний нийгэм ба олон нийтэд танин мэдүүлэх үйл ажиллагааг өрнүүлэх, тэдний зүгээс дэмжлэг авах



Семинарын зорилтууд:

- Оролцогч талуудын яриа хэлэлцээний агуулга, нөхцөл, зорилгыг тодорхойлох
- 2018 онд хийгдэх алхамуудаа тодорхойлох (roadmap)

▶ 2

Хийгдэх алхамуудын (Roadmap) бүтцийн санал ба хэлэлцэх асуудлууд I

Хугацаа	Алхам/Үйл явдал	Агуулга	Үр дүн, хяналт
Намар/Өвөл 2017/2018	Компани дээрх алхам	<ul style="list-style-type: none"> • Оролцогчид семинарын үр дүнгүүдийн тухай компанидаа танилцуулаад ТХЗ-уудыг хэрэгжүүлэх явцад тэдний бизнест гарч болох боломжууд болон асуудал бэрхшээлүүдийг тодорхойлно 	<ul style="list-style-type: none"> • Компаниуд Холбогч талд (Contact Point) буцаж тайлагнана • Холбогч тал хүмүүсийг хооронд нь холбож өгөх ба шаардлагатай бол компани дээрх алхамд туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна
2017 оны 11-р сарын 21	Хэлэлцүүлгийн тусгай хэсгүүд бүхий олон нийтийн хурал зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • Судалгааны үр дүнгийн тухай товч танилцуулга • ТХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хоорондын яриа хэлэлцээний үүргийг хэлэлцүүлэх • Бусад оролцогч талуудын боломжит оролцогчдод Хийгдэх алхамуудыг танилцуулах 	Холбогч тал хурлын тэмдэглэлийг тараах
2017 оны 11-р сараас 2018 оны эхэн үе хүртэл	Дараагийн алхамуудын дэлгэрэнгүй	<p>Холбогч тал:</p> <ul style="list-style-type: none"> • Өөр бусад оролцогч талуудыг тодорхойлон уялдаатай оролцогчдод мэдэгдэх • Оролцогчдын цаашдын санал зөвлөмжүүд болон тухайн үеийн хэрэгцээ шаардлагуудыг цуглуулах • Дараагийн үйл ажиллагаануудын агуулга ба хэв загварыг тодорхойлох, гаргах 	Холбогч талаар дамжуулан шинэ мэдээллийн тараах

Хийгдэх алхамуудын (Roadmap) бүтцийн санал ба хэлэлцэх асуудлууд II

Хугацаа	Алхам/ Үйл явдал	Агуулга	Үр дүн, хяналт
2018 Хавар	Семинар 1	Яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа – Бүх оролцогч талуудын төлөөлөгчдийн хамт яриаг эхлүүлэх • Байнгын, ил тод, харилцан болон хамтран суралцах сургалт/төслүүдийн бүтэц, системийг бий болгох	<ul style="list-style-type: none"> Оролцогчид бусад хамаарагч талуудтайгаа харилцахын тулд өөрсдийн байгууллагын дүрэм журмыг шалгах, хариуцах хүнийг томилох Холбогч тал туслалцаа үзүүлнэ
2018 оны 6-р сар	Семинар 2	Таниулан мэдүүлэх, хүлээн зөвшөөрөх • Эхлээд Холбогч тал бүлгүүдийн "анхдагч оролцогчидтой" хамтран цаг үеийн асуудлууд ба шилдэг туршлагуудыг тодорхойлно • Амжилттай компаниудын шилдэг туршлага, сургамжуудаас болон гадаадын зөвлөхүүд (2 төлөөлөгч)-ээс суралцах	<ul style="list-style-type: none"> Оролцогчид өөрсдийн стратегидаа суралцсан зүйлсээ тусгана Холбогч тал туслалцаа үзүүлэх ба байнгын хоорондын харилцаагаар хангана
2018 оны 9-р сар	Семинар 3	„Олон нийттэй харилцах“ – Хариуцлагатай бизнесийн асуудлуудаар нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэрэглэгчид ба олон нийттэй хэрхэн харилцах нь	<ul style="list-style-type: none"> Оролцогчид өөрсдийн харилцаа холбооны стратегидаа суралцсан зүйлсээ тусгана Холбогч тал туслалцаа үзүүлэх ба байнгын хоорондын харилцаагаар хангана
2018 оны 11-р сар	Нийтэд зориулсан хурал	<ul style="list-style-type: none"> Явц дундын үр дүн болон хүлээгдэж буй үр дүнгүүдийн тухай танилцуулна Хамгийн идэвхтэй, ахицтай оролцогчдыг шагнах 	<ul style="list-style-type: none"> Өөр Азийн орнууд дахь ижил төстэй төслүүдтэй уялдуулах, суралцах, солилцох боломж,

Түрүүлж тодруулах асуултууд

1. Бизнесийнхний зүгээс авч үзвэл оролцогч талуудын яриа хэлцлийн зорилго юу байх вэ?
2. Компаниуд болон холбоодын зүгээс бусад оролцогч талуудтай ямар асуудлаар хэлэлцэхийг илүүтэй хүсэж байна вэ?
3. Бизнесийнхний зүгээс яриа хэлцэл, сургалт, мэдээлэл мэдлэг солилцох болон бусад чиглэлүүдээр улс төр ба иргэний нийгэмд юу санал болгож, ямар хувь нэмэр оруулж чадах вэ?
4. Танай байгууллагын зүгээс авч үзвэл нэг жилийн яриа хэлцлийн эцсийн үр дүн ямар байх вэ?

ОРОЛЦОГЧДЫН ГАРГАСАН САНАЛУУД:

- Бүх түвшинд Тогтвортой хөгжлийн зорилтын талаар ойлголт өгөх. /Бага насны хүүхдүүд, Залуу үеийнхнийг хамруулах/
- Бизнесийн байгууллагууд бодит ажил хэрэгжүүлэх, PR гэхээс илүүтэй өдөр тутамдаа зарчмаа хэрэгжүүлэх.
- Сайн засаглалыг хэрэгжүүлэх бэлэн загвар, моделийг гаргах.
- Нийгмийн хамтын хариуцлагыг хэрэгжүүлэх.
- Төрийн бус байгууллагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.
- Төр засгийн байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх.
- Төр, хувийн хэвшил, ТББ-ын удирдлагуудын түвшинд сар бүр хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулах
- 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулах форумгаар дамжуулан, Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар хэлэлцэж, тодорхой шийдлүүдэд хүрэх.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд байгууллага юу хийж болох талаар хэрэгжүүлж болох алхамуудыг тодорхойлсон гарын авлага, бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх. Мөн салбараасаа хамаараад өөр өөр (хэрэгжүүлэх алхам, ойлголт)
- Салбар бүрийн мэргэжилтнүүд нэгдээд баримт бичгээ хамтран боловсруулах.

- Бизнесийн холбоод нэгдээд Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийнхэнд зориулсан гарын авлага боловсруулах.
- Олон улсын байгууллагууд болон судалгаа шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд уялдаа холбоогоо сайжруулах. Үр дүнтэй судалгаа, шинжилгээ, гадаад дотоод экспертүүдийн тусламжтайгаар олон талт шийдэл хувилбарыг гаргаж, хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.
- Төр засгийн байгууллагын хэрэгжүүлэх дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын талаар хэлэлцүүлэг хийж, энэ талаар нэгдсэн нэг ойлголттой болох, улмаар энэхүү дунд, урт хугацааны бодлоготой хийгдэх ажлуудаа уялдуулах, хувь нэмрээ тодорхойлох.
- Хувийн хэвшлийн байгууллагуудыг сэдэлжүүлэх.
- Холбоодын нэгдмэл байдлыг сайжруулах, тэдгээр холбоодыг нэгдсэн чиглэл бодлогоор хангах.
- Судалгааны үр дүнтэй холбоотой хэлэлцүүлгийг салбар бүрийн төлөөлөл нэг дор хийж байгаагаас гадна давхар салбар бүрээр нь тусгайлсан хэлэлцүүлэг хийвэл тодорхой үр харагдана, нэг салбарын төлөөлөл нэг дор цуглаад ярилцахад уялдаа холбоотойгоор асуудлаа олон талаас ярилцах боломж бүрдэнэ.
- Тогтвортой хөгжлийн зорилтыг нийтэд нь гэхээс илүү эхний ээлжинд тодорхой нэг сэдэв, чиглэлийг сонгоод хэрэгжүүлэх.
- Шалгуур үзүүлэлт гарган, компанийн нийгмийн хариуцлагыг үнэлэх, мөн компаниудыг дотор нь ангилах.
- Хувийн хэвшилд тулгуурласан Мэргэжил, сургалтын төвүүдийг бий болгож, шаардлагатай боловсон хүчинг бэлтгэх.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Конрад-Аденауэр-Сан
- Компанийн Засаглалын Хөгжлийн Төв

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД:

- Нэгдсэн Үндэстний Байгууллага
- Оюутолгой ХХК
- Төрийн Банк
- Монос Групп
- Эрдэнэс Монгол ХХК
- Сүү ХК
- Нова Терра ХХК
- Gerhub
- Монголын Бизнесийн Зөвлөл
- Монголын ББСБ-уудын Холбоо
- Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
- Монголын Банкуудын Холбоо
- Зориг Сан
- Амаржаргал Сан
- Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
- Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадвар Судалгааны Төв



